

ТЭМДЭГЛЭЛТ ОЙ

**ХЯТАД ДАХЬ ИМПЕРИАЛИЗМЫГ ЭСЭРГҮҮЦСЭН
ХӨДӨЛГӨӨН**

Хүн төрөлхтөн капитализмаас социализмд шилжих шинэ эрин үеийг нээсэн агуаа их Октябрийн социалист их хувьсгалын ялалт нь Дорно дахны улс түмний, түүний дотор хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний өрнөлтөд шийдвэрлэх нөлөө үзүүлсэн билээ. Октябрийн хувьсгалын чөлөөлөх үзэл санаа хятадын ард түмнийг гадаадын империализм, дотоодын феодал, харгис цэргийн эрхтнүүдийн дарлал мөлжлөгийн эсрэг тэмцэлд уриалан дуудлаа. Үүний тодорхой илрэл бол Хятадад 1919 оны 5-р сарын 4-нд гарсан империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн юм.

Хагас колонийн хоцрогдсон Хятад орныг империалист гүрнүүд юуны өмнө Япон улс «нөлөөнийхөө хүрээнд» татан оруулах гэж хурц ширүүн тэмцэлдэж байна.¹ Японы империалистууд Германы эзэмшилд байсан хятадын Шаньдун мужийг 1914 онд эзлэн авч улмаар түүнийг Японы цэрэг-эдийн засгийн нэг гол түшиц газар болох, хятадын засгийн газрыг японы тоглоомын дэглэм болгон ашиглах, империалист бусад гүрний Хятад дахь нөлөөг сулруулах зорилгын үүднээс «21 зүйлт шаардлага» гэгчийг Хятадад тулган хүлээлгэх явууллага хийж байлаа.

Дэлхийн I дайны дараа 1918 оны 11-р сард эхэлсэн Парисын энх тайвны бага хурлыг хятадын олон нийт Шаньдун дахь Германы эзэмшлийг Хятадад эргүүлэн өгөх, империалист японы Шаньдуныг авах гэсэн өнгөлзлөгийг эцэс болгох шийдвэр гаргах байх гэж найдаж байсан юм. Гэтэл энэ итгэл найдвар талаар болж 1919 оны 4-р сарын эцсээр Шаньдун дахь германы эзэмшлийг Японд шилжүүлэх шийдвэрийг Парисын бага хуралд оролцогч империалист гүрнүүд гаргажээ.

Энэхүү шийдвэр нь хятадын олон нийтийн дургүйцэл зэвүүцлийг хүргэж империализмыг эсэргүүцсэн эх оронч хөдөлгөөн өрнөх шууд шалтаг болжээ. 1919 оны 5-р сарын 4-нд Бээжин хотын төв-Тяньаньмэний талбайд оюутнуудын санаачилгаар 13 дээд, дунд сургуулийн 3 мянга гаруй оюутан сурагчид оролцсон жагсаал цуглаан болов.² Хятадыг хуваан боолчлоход чиглэгдсэн империалист гүрнүүдийн ажил явууллагыг эсэргүүцэж байгаагаа илэрхийлэн «үндэсний бүрэн эрхээ хамгаалъя» «Шаньдунд эрхээ сэргээе», «21 зүйлт шаардлагыг хүчингүй болгоё», «үндэсний урвагчдыг цээрлүүлье» гэсэн уриан дор жагссан оюутан залуус Японтой хэд хэдэн эрх тэгш биш гэрээ байгуулсан тэр үеийн Бээжингийн засгийн газрын сайд Цао Жүлиний байрыг шатааж, Японд сууж байсан хятадын элчин сайд Чжан Цзунсянийг барьж зоджээ. Гэвч хятадын эрх баригчид цэрэг цагдаагийн хүчээр жагсагчдыг хөөн тарааж олон хүнийг баривчилсан ба 30 гаруй хүнийг харгис хэрцгийгээр зодож жанчжээ.

¹ «Новейшая история Китая» 1917-1927. М., 1983, с. 54

² Хятадын коммунист намын түүхийн лекц (хятад хэлээр) Цзилинь. 1981. 13-р тал.

Жагсаалд оролцогчдыг хатуу ширүүн харгислан дарсан боловч Японы империализм түүний гар хөл бологч Дуань Цижуйгийн милитарист бүлгийнхнийг эсэргүүцсэн 5-р сарын 4-ний энэхүү хөдөлгөөнд хятадын бусад олон хотын оюутан залуус, хүн амын янз бүрийн давхаргынхан татагдан орж империализмыг эсэргүүцсэн хятадын ард түмний эх оронч хөдөлгөөн газар сайгүй өрнөлөө. Бээжингийн оюутнуудын жишээгээр орон нутагт оюутан залуусын нэгдсэн холбоо байгуулагдаж, хүн амын дунд империализмыг эсэргүүцсэн ухуулга хийж, японы таваарт хориг тавих болов. Империализмыг эсэргүүцсэн энэхүү хөдөлгөөний төв нь аажмаар хятадын худалдаа аж үйлдвэрийн томоохон хот Шанхайд шилжиж Шанхай, Цзинань, Гуанчжоу болон бусад хотод оюутнуудын шаардлагыг дэмжсэн олон нийтийн ажил хаялт, жагсаал, цуглаан болж байжээ.

5-р сарын 4-ний хөдөлгөөний гол лоозон, дэвшүүлсэн зорилго нь японы империалистүүдийн хүчээр булаан авсан Шаньдун мужийг хятадад буцаан авах, тэдэнтэй гэрээ байгуулан ард түмнийхээ эрх ашгаас урван тэрсэлсэн Бээжингийн засаг захиргааныханыг албан тушаалаас нь зайлуулах явдал байв. Энэхүү хөдөлгөөн хоёр сар шахам үргэлжилсний эцэст Бээжингийн засаг захиргааны бүрэлдэхүүнээс үндэсний урвагч зарим этгээдийг зайлуулж, империалист гүрнүүдтэй хятадын үндэсний эрх ашгийг хохироосон гэрээ байгуулахаас Бээжингийн засгийн газрыг арга буюу татгалзахад хүргэжээ.

5-р сарын 4-ний хөдөлгөөнд ажилчид оюутан сурагчид, хотын жижиг хөрөнгөтөн, худалдаачин, үндэсний том хөрөнгөтөн зэрэг хотын хүн амын янз бүрийн давхаргынхан оролцсон боловч хятадын хүн амын дийлэнх олонх болох тариачид тархай бутархай түгжигдмэл, зохион байгуулалтгүй, хоцрогдмол байдлынхаа улмаас империализмыг эсэргүүцсэн энэхүү хөдөлгөөний гадна үлдсэн байна.³ Ажилчин нийгмийн манлай хүчин болоогүй, тэдний тэмцлийг зохион байгуулж удирдах нам байгуулагдаагүй байсан зэрэг шалтгаанаас 5-р сарын 4-ний хөдөлгөөн нь тэмцлийн зорилго, шинж чанар, хөдөлгөх хүчин, ангийн агуулгаараа хөрөнгөтний ардчилсан хөдөлгөөний шинж чанартай байлаа. 5-р сарын 4-ний империализмыг эсэргүүцсэн эх оронч хөдөлгөөн нь ажилчин анги, түүний манлай нам, ажилчин тариачны ангийн бат холбоо байхгүйгээр хятадын хувьсгал, хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний тэмцэл ялалтад хүрч чадахгүйг харуулсан юм.

«5-р сарын 4-ний хөдөлгөөн» нь империализм, феодализмыг эсэргүүцсэн хятадын ард түмний эх оронч ардчилсан хувьсгалт хөдөлгөөний эхлэл болж хятадын түүхэнд чухал байр суурь эзлэх болов. Чухамхүү энэ хөдөлгөөний нөлөөгөөр хятадын олон нийт хятадыг үүрд боолчлох санаархалаасаа олон улсын империализм сайн дураараа татгалзахгүй гэдгийг ойлгож авсан байна. Үүнтэй холбогдуулан тэмдэглэхэд 1919 оны 7-р сарын 25-нд Зөвлөлт засгийн газраас «Хятадын ард түмэн ба Өмнөд, Хойд Хятадын засгийн газарт» гэсэн уриалга гаргаж,⁴ хаант оросын засгийн газрын япон болон империалист бусад гүрнүүдтэй хамтран хятадад тулган хүлээлгэсэн хүчээр түрээ барих, шударга бус гэрээ хэлэлцээрийг хүчингүй болгосон тухай зарласан явдал хятадын ард түмний үндэсний эрх чөлөөний хувьсгалт тэмцлийн цаашдын өрнөлтөд чухал ач холбогдолтой үйл явдал болсон юм.

³ «Проблемы дальнего Востока» 1979, № 2, с. 156.

⁴ Документы внешней политики СССР. т. 1-10. М., 1957-1965. т. 2, с. 222.

Аугаа их Октябрийн хувьсгалын шууд нөлөөгөөр Хятадад марксизм-ленинизмийн үзэл санаа улам өргөн түгэн дэлгэрч байсан үе 1919 оны 5-р сарын 1-ний империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөнд идэвхтэй оролцогчдын дотор Ли Дажао, Цюй Цюбо, Пэн Бай, Лу Синь нарын зэрэг хятадын коммунист намын ирээдүйн нэрт зүтгэлтнүүд, марксизм-ленинизмийн үйл хэргийг анхлан хятадад сурталчлагчид, тууштай интернационалчид байлаа. Гадаадын империализм түүний гар хөл бологч харгис дэглэмийн эсрэг улс төрийн ухамсартай тэмцэлд хятадын хөдөлмөрчин олон нэгдэн идэвхтэй оролцох эхлэлийг чухамхүү 5-р сарын 4-ний хөдөлгөөн тавьсан бөгөөд уг хөдөлгөөний явцад ажилчин анги анх удаа улс төрийн тэмцлийн тавцан дээр биеэ даасан хувьсгалт хүчин болон гарч улмаар түүний дайчин манлай коммунист нам байгуулагдах нөхцөл бүрэлдсэн юм. Чухам үүнд хятадын ард түмний империализмыг эсэргүүцсэн 5-р сарын 4-ний хөдөлгөөний түүхэн ач холбогдол оршино.

«5-р сарын 4-ний хөдөлгөөн» нь хятадын ард түмний эрх чөлөөний тэмцлийн түүхэнд шинэ үе нээж, гадаадын империализм, монопольт капитализмыг эсэргүүцэх хувьсгалт уламжлалыг бий болгосон нь хятадын ардын ардчилсан хувьсгалын ялалтыг чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Ийнхүү 65 жилийн тэртээ Хятадад империализмыг эсэргүүцсэн хөдөлгөөн өрнөсөн нь хүн төрөлхтөний амьдралын шинэ үеийг нээсэн аугаа их Октябрийн ялгуусан үзэл санааны хүч Дорно дахинд, түүний дотор Азийн томоохон орон Хятадад хувьсгалжуулагч нөлөө үзүүлсний нэгэн тод жишээ болсон юм.

Хятадын одоогийн эрх баригчид империалист харгис хүчний эсрэг тэмцэж ирсэн энэхүү түүхэн уламжлал, ард түмнийхээ үндэсний язгуур эрх ашгийг хөсөрдүүлэн, энх тайван, дэвшил хөгжлийн өмөг түшиг болсон ЗХУ-ыг үзэн ядаж, дайсагнаж байгаа империализмын хамгийн харгис хүчинтэй нягт хамтран ажиллаж байна.

АНУ-ын ерөнхийлөгч Р. Рейнаны хятадад хийсэн айлчлал үүний нэгэн тод баталгаа боллоо.

Хятадын ард түмний хувьсгалт тэмцэл ба БНМАУ байгуулагдсаны дараах аж ахуйн бүтээн байгуулалтанд ЗХУ сэтгэл харамгүй асар их тусламж үзүүлж байсныг хятадын ард түмэн мартаагүй. Харин империалист гүрнүүдтэй эвсэн ажиллах бодлогоо хятадын өнөөгийн эрх баригчид яаж ч нарийн болголоо гэсэн «5-р сарын 4-ний хөдөлгөөн»-өөр үүсэн бий болсон үндэсний урвагч, гадаадын империализмын эсрэг тэмцлийн ариун шударга уламжлалыг хятадын ард түмний оюун санаанаас арчин хаяж чадахгүй.

Он цаг улирах тутам ариун шударга уламжлалын залгамжлах чанар тодрох жамтай бөгөөд империализмтай хамтран ажиллах ийм бодлого хятадын хөдөлмөрчин олны дэмжлэг, итгэлийг олохгүй нь тодорхой.

Л. Бэгзжав